

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№23/26


Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл болон Их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь заалт, 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт, 87.2 дох заалт, 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт 88 дугаар зүйлийн 88.1 дэх заалт, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дох заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**


1. Компани эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх зорилгоор нэгдмэл сонирхолтой этгээдээс 5,000,000 /таван сая/ ам.доллар хүртэлх үнийн дүн бүхий зээл авч сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрсүгэй. Зээлийн нөхцлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Зээл авахтай холбоотой их хэмжээний хэлцэл хийх, зээлийн гэрээг байгуулах, зээлийн барьцааг хангах болон зээл авахтай холбоотой бүхий л арга хэмжээг авах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д олгосугай.
3. Зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дарга Д.Даянбилгүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын дэд хорооны дарга Д.Амгаланбаяр, гишүүн О.Уранбайгал, М.Туяа нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолд компанийн тухай хуулийн дээр дурдсан холбогдох заалтуудыг үндэслэн сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал өгөхөөс түтгэлзсэн болохыг дурдсугай.

ЗӨВШӨӨРСӨН:

 Б.ЛХАГВАДОРЖ

 Д.ДАЯНБИЛГҮҮН

ULUC BINGOL

 О.УРАНБАЙГАЛ



“BDSEC” JSC
BOARD OF DIRECTORS RESOLUTION

12 August 2026

№ 23/26

Ulaanbaatar city

**On Granting Approval to Enter into a Conflict-of-Interest Transaction and a
Major Transaction**

Pursuant to Articles 76.1.16, 87.1.1, 87.2, 76.1.17, 88.1, 89.1, 92.1 and 92.2 of the Company Law, and based on the voting results of the regular meeting of the Board of Directors held on 12 August 2026, IT IS HEREBY RESOLVED:

1. To approve the company entering into a conflict-of-interest transaction by obtaining a loan of up to USD 5,000,000 (five million US dollars) from a related party for the purpose of financing the company's working capital. The terms and conditions of the loan shall be approved as set forth in the Appendix to this Resolution.
2. To grant Chief Executive Officer B. Lkhagvadorj full authority to enter into a major transaction in connection with obtaining the loan, execute the loan agreement, provide collateral for the loan, and take all actions related to obtaining the loan.
3. To assign D. Dayanbilguun, Chairman of the Board of Directors; D. Amgalanbayar, Chairman of the Audit Subcommittee under the Board of Directors; and members O. Uranbaigal and M. Tuya to oversee the implementation of the loan.
4. To note that, pursuant to the relevant provisions of the Company Law referred to above, the members of the Board of Directors having a conflict of interest abstained from voting on this Resolution.


APPROVED BY:

_____ B. LKHAGVADORJ

_____ D. DAYANBILGUUN

_____ ULUC BINGOL

_____ O. URANBAIGAL





ANDREW BROWN

Анхбаяр-сүр
Брокер, дилэгийн
"БНДХСЕК"

M. TUYA

ТЦА АН

11157021472-2053482

D. AMGALANBAYAR

CHAIRMAN OF THE BOARD:

/D. DAYANBILGUUN/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№24/26


Улаанбаатар хот

Биржийн бус зах зээлд бонд гаргах тухай

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны Өрийн хэрэгслийн бүртгэлийн журмын 2.8, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “БидиСЕК ҮЦК” ХК-ийн 9%-13% хүүтэй, 2 жилийн хугацаатай, хагас жил тутам хүү төлөх нөхцөлтэй, ам доллар төгрөгийн ханштай уясан \$ 2,000,000 (хоёр сая ам доллар) хүртэлх үнийн дүн бүхий “Бондын хөтөлбөр” – ийг мэргэжлийн хөрөнгө оруулагчдад биржийн бус зах зээл дээр санал болгон гаргахыг зөвшөөрсүгэй,
2. Бондын нэрлэсэн үнийг \$ 100 (нэг зуун ам доллар) – оор тогтоосугай,
3. Бондын барьцаа: Компанийн зээлжих зэрэглэлийн үнэлгээнд үндэслэн хөрөнгө оруулагч нарт санал болгохыг зөвшөөрсүгэй,
4. Компанийн зээлжих зэрэглэлийг “Монголын хөрөнгө оруулалтын зэрэглэлийн эжинси ҮЦК” ХХК – р тогтоолгохыг зөвшөөрсүгэй,
5. Үнэт цаас гаргагч бондын үндсэн болон хүүгийн төлбөрийг тухайн төлбөр төлөхийн өмнөх өдрийн Монголбанкны ам.долларын хаалтын ханшаар тооцож гүйцэтгэнэ,
6. Хөтөлбөрийн хүрээнд өрийн хэрэгслийг хэсэгчлэн санал болгон гаргах тухай бүр бондын нөхцлийг тодорхойлох, зохицуулагч байгууллагуудад бондын хөтөлбөрийг бүртгүүлэх холбогдох зөвшөөрлийг авах, анхдагч зах зээлийн арилжаа зохион байгуулж бондын санхүүжилтыг татан төвлөрүүлэх, шаардлагатай эсвэл зохистой гэж үзсэн холбогдох бүхий л баримт бичигт гарын үсэг зурах, баталгаажуулах, шаардлагатай бүх арга хэмжээг авч энэхүү тогтоолын гүйцэтгэлийг хангах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Лхагвадоржид олгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№25/26

Улаанбаатар хот

Аудитын компани сонгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.10 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. 2026 оноос компанийн санхүүгийн тайланд аудит хийх компаниар “Интер аудит” ХХК-г сонгосугай.
2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн бүхий л арга хэмжээг авах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын дэд хорооны дарга Д.Амгаланбаяр, гишүүн О.Уранбайгал, М.Туяа нарт олгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№26/26

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн сургалтын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн сургалтын төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр баталсугай.
2. ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга Т. Шүүдэрцэцэг-т дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№27/26

Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Ногдол ашгийн бодлого”-ыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№28/26

Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Цалин, урамшууллын бодлого”-ыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай,
2. ТУЗ-ийн цалин, урамшууллын хорооны дарга Б.Энхбаяр, гишүүн Hitoshi Tani, Andrew Brown нарт энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№29/26


Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Тогтвортой хөгжлийн бодлого”-ыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№30/26

Улаанбаатар хот

Бодлогын баримт бичиг батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.12, 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Мэдээллийн нууц аюулгүй байдлын бодлого”-ыг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэх захирал Б.Лхагвадорж-д энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн бүрэн эрхийн хүрээнд авах шаардлагатай гэж үзсэн арга хэмжээнүүдийг авах эрхийг олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№31/26

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Эрсдлийн удирдлагын журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Компанийн эрсдлийн удирдлагын мэргэжилтнээр О. Уранбайгал-г томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№32/26


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Дотоод хяналтын үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Компанийн дотоод хяналтын мэргэжилтнээр Н. Батгэрэл-г томилсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:**



/Д.ДАЯНБИЛГҮҮН/

“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 12 өдөр

№33/26

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 08-р сарын 12-ны өдрийн ээлжит хурлын санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн “Нэр дэвшүүлэх хорооны журам”-ыг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны дарга М.Туяа, гишүүн Б.Лхагвадорж, Uluc Bingol нарт энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:



/Д.ДАЯНБИЛГҮҮН/